



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2023 оны 12 сарын 11 өдөр

Дугаар 46

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 35 дугаар хуралдааны тэмдэглэлд:

ХХХҮ.78. ХЭЛЭЛЦСЭН нь:

Гаалийн байгууллагын албан хаагчдын сургалтын асуудлыг цогцоор нь багтаасан орчин үеийн шийдэл бүхий “Зайн сургалтын төв” байгуулах зорилгоор ашиглалтын шаардлага хангахгүй байгаа “Горхи мэлхий хад” амралтын газрыг дахин төлөвлөлтөд хамруулах тухай.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Гаалийн ерөнхий газрын харьяа “Горхи мэлхий хад” амралтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгүүд нь сэргээн засварлах боломжгүй болсон, ашиглалтын шаардлага хангахгүй, засвар хийхэд эдийн засгийн хувьд ашиггүй, газар хөдлөлтөд тэсвэргүй, ашиглалтын шаардлага хангахгүй, зарим бүтээц хийцүүд хэсэгчлэн аваарын байдалд байгаа нь Нийслэлийн хотын стандарт, хяналтын газрын улсын ахлах байцаагчийн дүгнэлтээр Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтад нийцэхгүй байгаа тул Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 353 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм”-ийн 3.3 дахь заалтын дагуу “холбогдох байгууллагад хандаж үзлэг шинжилгээг хийлгэх, ашиглалтын хэвийн нөхцөлийг хангуулах нь зүйтэй” гэж, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Барилга архитектурын сургуулийн Оношилгоо, зураг төсөл, судалгааны “Реконстракшн” төв Горхи мэлхий хад амралтын газрын барилга болон ажилчдын 8 айлын 4 орон сууцны барилга нь “ашиглалтын шаардлага хангахгүй байна” гэж 2023 оны 02-13-01/025/92 дугаар дүгнэлтийг тус тус гаргасан байна.

Гаалийн ерөнхий газрын харьяа “Горхи мэлхий хад” амралтын газрын нийслэлийн Налайх дүүргийн 6 дугаар хороо, Горхийн баруун салаанд 2012/20 дугаартай газар ашиглах гэрчилгээтэй 1 га талбай бүхий газрыг албан хаагчдыг урт, богино хугацаанд сургах, мэргэшүүлэх “Зайн сургалтын төв” байгуулахаар дахин төлөвлөлтөд оруулах асуудлыг дэмжих нь зүйтэй гэж үзэв” гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



132002550
35-r huraldaah.docx